

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2008 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч  
С.Батдэлгэр

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Бид сүүлийн 3 жилд шүүхийн шинэчлэлийг улам гүнзгийрүүлэх, эрчимжүүлэхийн тулд дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, эмх цэгц, хяналтыг сайжруулах, шүүгч нарын ажлын ачаалалыг бууруулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах, анхан болон давж заалдах шатны шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааг чанарын шинэ түвшинд гаргаж, шүүгчдийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, шүүхийн мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох, өөрийн вэб сайттай болох;

Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний нэгдсэн стандартыг боловсруулан мөрдүүлэх, шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө хүмүүжлийн ач холбогдлыг мэдэгдэхүйц дээшлүүлэх, шүүгч, ажилтны сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, ёс зүйн дүрмийг чанд баримтлах;


Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулах, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаанд гарсан ололт амжилтыг бататгах, эрчимжүүлэх, үр дүнг тооцох, шүүхийн сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, шүүх эрх мэдлийг хараат бус, хариуцлага хүлээдэг, шударга, мэдрэмжтэй, хүртээмжтэй, бүтээмжтэй хэрэгжүүлэх, шүүгч, ажилтны хэвийн ажиллах нөхцлийг хангах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг зорилтыг тус тус дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ чиглэлүүдэд зарим тодорхой үр дүн, ахиц гарч үүнд та бүхний мэдлэг чадвар, оюун ухаан, идэвхи зүтгэл, санал санаачлага, хамгаас чухал байсныг тэмдэглэхэд таатай байна.

Улиран өнгөрч буй 2008 он ажил хөдөлмөрийн өрнүүн, амжилт бүтээлээр арвин жил байлаа.

Та бидний хөдөлмөр зүтгэлийг Монголын төр өндрөөр үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга М.Дамирансүрэн нар "**Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон**"-гоор, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Ерөнхий шүүгчийн шүүн таслах ажиллагаа хариуцсан референт З.Нацаг нар "**Алтангадас**" одонгоор, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагч Г.Гандмаа, үйлчлэгч Д.Загдсүрэн нар "**Хөдөлмөрийн хүндэт**" медалиар, шүүгч Д.Пунцаг "**Шүүхийн тэргүүний ажилтан**" цол тэмдгээр, жолооч Б.Пүрэв Шүүхийн Ерөнхий зөвлөлийн "**Хүндэт тэмдэг**"-ээр, Судалгааны төвийн хууль тогтоомжийн системчлэлийн ажил хариуцсан ахлах зааварлагч Ш.Даваадулам ХЗДХЯамны "**Хүндэт жуух бичиг**"-ээр тус тус шагнагдлаа.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар Хүний эрхийг тууштай хамгаалах, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжил, шинэчлэлтэд болон шүүхийн хүний нөөцийг бэлтгэн бэхжүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг үнэлж Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Б.Пүрэвнямыг Улсын Дээд шүүхийн "**Хүндэт тэмдэг**"-ээр, Дорнод аймгийн Сум дундын шүүхийн ерөнхий шүүгч С.Ганчимэг, Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуул хамгаалалтын албаны 1 дүгээр салбарын дарга, дэд хурандаа Ж.Амаржаргал нарын **16** хүнийг Улсын Дээд шүүхийн "**Жуух бичиг**"-ээр тус тус шагналаа.

Сүүлийн **3** жилийн байдлаар шүүгч, ажилтан, ахмадуудаас Гавъяат хуульч цолоор **2**, Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор **9**, Алтан гадас одонгоор **4**, Хөдөлмөрийн хүндэт медалиар **7**, Шүүхийн тэргүүний ажилтан цол, тэмдэгээр **4**, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан цол, тэмдэгээр **2** хүн тус тус шагнагджээ.



Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах үүднээс [www.supremecourt.mn](http://www.supremecourt.mn) вэб сайтад тус шүүхийн үйл ажиллагаа, түүний талаарх мэдээ, мэдээлэл, шүүх хуралдааны зар, хууль тайлбарласан тогтоол, заавар, дүрэм, журам, Ерөнхий шүүгчийн дангаар болон хамтран гаргасан захирамж зэргийг байршуулж, цахим хэлбэрээр шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүллээ.

- 2008 он эрдмийн шим арвин, номын буян дэлгэрсэн он болж өнгөрлөө. Тухайлбал,
- Улсын Дээд шүүхээс 2004-2007 онд хууль тайлбарласан тогтоолыг эмхэтгэн хуулийн албан ёсны тайлбарын эмхэтгэл;
  - “Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмжийн эмхтгэл”;
  - “Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх онол практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл;
  - “**Шүүхийн 2007 оны ажлын тайлан**” зэргийг хэвлүүлж олны хүртээл болголоо.

Мөн

- “Ханнс-Зайделийн сан”-тай хамтран “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”;
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”-ын хоёр дахь хэвлэл тус тус хэвлэлтэд шилжиж,
- Одоо “Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, “Иргэний хуулийн дэлгэрэнгүй тайлбар”-ууд бүтээгдэж байна.

Улсын Дээд шүүхээс дэлгэрэнгүй тайлбар гаргаж буй нь эрх зүйт ёсны төрийн жишигт нийцсэн, хуулийг шинжлэх ухаан, онол, хууль зүйн техникийн үүднээс тайлбарлах явдлыг гүнзгийрүүлсэн, хууль зүйн шинжлэх ухааны болон хууль зүйн сургалтад практик аргачлалыг ойртуулсан олон талын ач холбогдолтой ажиллагаа боллоо гэж үзэж байна.

2008 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Шүүгчдийн зөвлөл хуралдаж, ШЕЗ-ийн гишүүнээр анхан шатны шүүхээс Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Н.Сүхбаатар, дагнасан шүүхээс Баянхонгор аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Тунгалагсайхан нарыг сонгов.

Мөн хурлаар Шүүхийн мэргэжлийн хороо болон Сахилгын хороо, Шүүгчдийн холбооны 2007 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцлээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр зарлигаар Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, 2008 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 273 дугаар зарлигаар Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, 2008 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 407 дугаар зарлигаар Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан нарыг танхимын тэргүүний албан тушаалд улируулан томиллоо.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа. Ингээд Улсын Дээд шүүхийн 2008 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.

### Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар


2008 оны шүүн таслах ажиллагааны тайланг товч танилцуулбал:

### 1. Нийт шүүгчдийн хуралдаан:

2008 онд нийт шүүгчдийн хуралдааныг 17 удаа зарлан, нийт 17 өдөр хуралдуулж, бүгд 47 асуудал хэлэлцэж, 47 тогтоол гаргасны дотор, эрүүгийн 26, иргэний 3, захиргааны 1 хэрэг тус тус хянан шийдвэрлэж, хуулийг тайлбарласан 16 тогтоол гаргаж, 6 аймгийн шүүхийн ажлыг шалган тусалсан дүнг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо 9-өөр, хуулийн тайлбар 7-гоор буурч, эрүүгийн хэрэг 6-гаар, иргэний хэрэг 1-ээр тус тус нэмэгджээ. Үүнийг сүүлийн 3 жилийн байдлаар харьцуулан харуулъя.


Нийт шүүгчдийн хуралдааны үзүүлэлт



### 2. Эрүүгийн хэргийн танхим:


Эрүүгийн хэргийн танхим 2008 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар хяналтын журмаар эрүүгийн 636, цагаатгалын 27, нийт 663 хэрэг хүлээн авч, 443 эрүүгийн, 27 цагаатгалын буюу 470 хэргийг шүүх хуралдаанаар хянаж шийдвэрлэж, 84 хэргийг хянан буцааж, 93 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо 16 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 663 хэргээс



Хяналтын журмаар Танхимын тэргүүн Д.Батсайхан 120, шүүгч Ч.Ганбат 118, Б.Доржготов 116, Б.Бат-Эрдэнэ 110, С.Нямжав 105, Ц.Сумъяа 1, Ерөнхий шүүгчийн ажлын алба 93 эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.


Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг



**Хяналтын шатны** эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **417**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **416**, Ч.Ганбат **405**, Б.Доржготов **404**, С.Нямжав **383** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **347**, шүүгч Б.Доржготов **33**, Б.Бат-Эрдэнэ **27** С.Нямжав **19**, Ч.Ганбат **9** хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Шүүгч Ч.Ганбат **112**, Б.Доржготов **102**, С.Нямжав **100**, Б.Бат-Эрдэнэ **85**, Танхимын тэргүүн Д.Батсайхан **70** хэрэг тус тус **илтгэсэн** байна.



**Эрүүгийн хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **77** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **6** хэрэг хэлэлцжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн **470** хэргийн **53.8** хувь буюу **253** хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосон бол **21.3** хувь буюу **100** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, **24.9** хувь буюу **117** хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **100** тогтоол, магадлалын **24** хувь буюу **24** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **2** хувь буюу **2** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **1** хувь буюу **1** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **73** хувь буюу **73** шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **117** тогтоол, магадлалтай хэргээс **63** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, **14** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** анхан шатны шүүхэд буцааж, **27** хэргийг **хэрэгсэхгүй** болгож, **7** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон, шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон **6** хэрэг байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **27** хэргийн **4-т** нь хэлмэгдэгсдийн овог, нэрийг өөрчилж, **20** хүнд холбогдох **16** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж, давхар цагаатгасан **6** хэргийн магадлалыг хүчингүй болгож, **1** хэргийн тогтоолыг хэвээр үлдээжээ.

**Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **26** хэрэг хянан хэлэлцэгдсэний **7** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **19** нь бусад хэрэг байв.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **87,4** хувь буюу **411** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн **гомдлоор**, **7,6** хувь буюу **36** нь улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **4,8** хувь буюу **23** нь прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **48**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **22**, Б.Доржготов **9**, С.Нямжав **4**, Ч.Ганбат **1** хэргийг тус тус хянан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлээр, мөн Ерөнхий шүүгчийн ажлын алба **88** хэргийг хянан зохих хариуг өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Тус танхим 2008 онд нийт **82** албан бичиг, **188** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Д.Батсайхан **66** албан бичиг, **171** өргөдөл гомдол, шүүгч С.Нямжав **2** албан бичиг, **6** өргөдөл гомдол, Б.Бат-Эрдэнэ **7** албан бичиг, Ч.Ганбат **2** албан бичиг, **4** өргөдөл гомдол, Б.Доржготов **4** албан бичиг, **2** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, одоо **1** албан бичиг, цагаатгалын ажилтай холбоотой **5** өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **30** удаа оролцсоноос **10** удаа шүүх хуралдааныг даргалж, шүүгч Ч.Ганбат **64**, Б.Бат-Эрдэнэ **53**, С.Нямжав **44**, Б.Доржготов **39**, **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **54**, шүүгч Ч.Ганбат **49**, Б.Доржготов **66**, Б.Бат-Эрдэнэ **57**, С.Нямжав **39** удаа тус тус оролцож, Танхимын тэргүүн Д.Батсайхан **34**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **1** удаа тус тус шүүх хуралдааныг даргалжээ.


### 3. Иргэний хэргийн танхим:

Иргэний хэргийн танхим иргэд, байгууллагаас нийт **125** өргөдөл, гомдол хүлээн авч, **120**-ыг нь буюу **96** хувийг шийдвэрлэжээ. Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **118** өргөдөл гомдол хүлээн авч, **113**-ыг шийдвэрлэсэн байна.

Шүүгч Л.Бямбаа **4**, А.Доржготов **2**, Б.Ундрах **1** өргөдөл, гомдол тус тус хүлээн авч шийдвэрлэн, одоо **5** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Энэ онд тус танхим өмнөх оны **үлдэгдэл 28** хэрэг дээр **хяналтын** журмаар **633**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **148**, нийт **809** хэрэг хүлээн авчээ.

Нийт хүлээн авсан **809** хэргээс **620** хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, **152** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **22** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, одоо **18 хэргийн үлдэгдэлтэй байна.**



Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **86** хэрэг хүлээн авснаас **71**;


Шүүгч А.Доржготов **181** хэрэг хүлээн авснаас **177**;

Шүүгч Л.Бямбаа **179** хэрэг хүлээн авснаас **170**;

Шүүгч Б.Ундрах **152** хэрэг хүлээн авснаас **150**;

Шүүгч Д.Тунгалаг **53** хэрэг хүлээн авснаас **49** хэргийг хуралдаанд тус тус илтгэж шийдвэрлүүлжээ.

### Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2008 оны ажлын ачаалал



**Иргэний хэргийн хяналтын** шатны шүүх хуралдаан **54** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **12** хэрэг хэлэлцэн, нийт **617** хэрэг хянаж шийдвэрлэжээ.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **476** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос 405** хуралдааныг,

Шүүгч А.Доржготов **412** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **21** хуралдааныг,

Шүүгч Л.Бямбаа **375** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **26** хуралдааныг,

Шүүгч Б.Ундрах **239** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос **14** хуралдааныг тус тус даргалж, шүүгч Д.Тунгалаг **201** хэрэг шийдвэрлэхэд оролцжээ.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **6** удаа даргалж, **9** шүүх хуралдаанд оролцон, шүүгч Б.Ундрах **27**, Л.Бямбаа **23**, А.Доржготов **16**, Д.Тунгалаг **10** удаа шүүх хуралдаанд оролцсон байна.

Хяналтын шатны **захиргааны** хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **6** удаа даргалж, **18** хуралдаанд оролцож, шүүгч Л.Бямбаа **1** удаа даргалж, **68** удаа оролцож, Б.Ундрах **40**, А.Доржготов **35**, Д.Тунгалаг **31** хуралдаанд тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **659**-г гарганаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн захирамж **13**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” шүүгчийн захирамж **82**, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **539**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” захирамж **16**, бусад захирамж **9** байна.

Иргэний хэргийн танхим 2008 онд “Монголын Ардчилсан хөдөлгөөний нам”-ыг Улсын бүртгэлд шинээр бүртгэн улсын бүртгэлийн гэрчилгээ олгож,


“Монголын Социал Демократ нам”-ын дүрэм, “Монголын Ногоон нам”-ын дүрэм, “Иргэний Зориг нам”-ын дүрмийн өөрчлөлтийг тус тус шинэчлэн бүртгэжээ.

Мөн “Монголын Үндэсний эв нэгдлийн нам”-ыг татан буулгаж, “Монголын Уламжлалын нэгдсэн нам”-ын дүрмийн өөрчлөлтийг, “Монголын Эмэгтэйчүүдийн төлөө нам”, “Монголчуудын Амьдралыг дээшлүүлэх нам”, “Хүмүүнлэг Ардчилсан Ардын нэгдсэн нам”-ыг улсын бүртгэлд бүртгэхээс тус тус татгалзсан байна.

Түүнчлэн Улсын Их хурлын сонгуульд нам, эвслээс болон бие даан нэр дэвшигч **423** хүний өр, төлбөрийн талаарх тодорхойлолтыг хуулийн дагуу хугацаанд нь гаргаж, нэр дэвшигч нарт болон Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлжээ.

#### 4. Захиргааны хэргийн танхим:

Тайлангийн хугацаанд тус танхим нь **давж заалдах** журмаар **400**, **хяналтын** журмаар **211**, **Ерөнхий** шүүгчид гомдол гаргасан **49**, нийт **660** хэрэг хүлээн авчээ.



**Давж заалдах журмаар 370** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **9** хэргийг хянан буцааж, одоо **21** хэргийн;

**Хяналтын журмаар 196** хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, **4** хэргийг хянан буцааж, одоо **11** хэргийн;

**Ерөнхий шүүгчид** хянуулахаар ирүүлсэн **49** хэргээс **1** хэргийг нийт шүүгчдийн хуралдаанаар хянан хэлэлцүүлж, **44** хэрэгт албан бичгээр хариу өгч, одоо **4** хэргийн тус тус үлдэгдэлтэй байна.

Танхимын тэргүүн О.Зандраа давж заалдах журмаар 1 хэрэг хүлээн авч, шүүх хуралдаанд оруулж хэлэлцүүлэхгүйгээр хянан буцааж, хяналтын журмаар 25 хэрэг хүлээн авснаас 25 хэрэг;


Шүүгч Л.Атарцэцэг давж заалдах журмаар 78 хэрэг хүлээн авснаас 73 хэрэг, хяналтын журмаар 36 хэрэг хүлээж авснаас 32 хэрэг;

Шүүгч Д.Пунцаг давж заалдах журмаар 79 хэрэг хүлээн авснаас 75 хэрэг, хяналтын журмаар 37 хэрэг хүлээж авснаас 34 хэрэг;

Шүүгч Ц.Сумъяа давж заалдах журмаар 83 хэрэг хүлээн авснаас 78 хэрэг, хяналтын журмаар 40 хэрэг хүлээж авснаас 38 хэрэг;


Шүүгч Ч.Тунгалаг давж заалдах журмаар 79 хэрэг хүлээн авснаас 73 хэрэг, хяналтын журмаар 35 хэрэг хүлээж авснаас 34 хэрэг;

Шүүгч П.Цэцгээ давж заалдах журмаар 80 хэрэг хүлээн авснаас 71 хэрэг, хяналтын журмаар 38 хэрэг хүлээж авснаас 33 хэрэг тус тус илтгэж шийдвэрлүүлжээ.




Давж заалдах шатны шүүх хуралдааныг 44, хяналтын шатны шүүх хуралдааныг 37 өдөр хийж, өдөрт дунджаар 8 хэрэг хэлэлцэн, нийт 566 хэргийг хянан шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн танхимд давж заалдах журмаар хянуулахаар ирсэн 400 хэргээс нэг шүүгчид 80, хяналтын шатны журмаар хянуулахаар ирсэн 260 хэргээс нэг шүүгчид дундажаар 43 хэрэг тус тус ногдож байна.



Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгч Ц.Сумъяа 241 удаа оролцсоноос 103, П.Цэцгээ 238 удаа оролцсоноос 61, Ч.Тунгалаг 240 удаа оролцсоноос 86, Д.Пунцаг 209 удаа оролцсоноос 66, Л.Атарцэцэг 196 удаа оролцсоноос 58 удаа шүүх хуралдааныг даргалжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа 175 удаа оролцсоноос 150, шүүгч П.Цэцгээ 79 удаа оролцсоноос 2, Д.Пунцаг 72 удаа оролцсоноос 8, Ч.Тунгалаг 72 удаа оролцсоноос 1, Л.Атарцэцэг 68 удаа оролцсоноос 3, Ц.Сумъяа 62 удаа оролцсоноос 2 шүүх хуралдааныг тус тус даргалсан байна.



**Ерөнхий шүүгчид** гомдол гаргасан хэргээс Танхимын тэргүүн О.Зандраа **1** хэргийг Ерөнхий шүүгчийн дүгнэлтийг үндэслэн, Нийт шүүгчдийн хуралдаанд илтгэн шийдвэрлүүлжээ.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **47** удаа оролцсоноос **29** шүүх хуралдааныг даргалсан, шүүгч Ц.Сумъяа **56** удаа хуралдаанд оролцож, **1** хэргийг илтгэсэн, Д.Пунцаг **36**, П.Цэцгээ **36**, Л.Атарцэцэг **32**, Ч.Тунгалаг **31** удаа шүүх хуралдаанд оролцжээ.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа **129** удаа оролцсоноос **119** шүүх хуралдааныг даргалж, шүүгч Ц.Сумъяа **90**, П.Цэцгээ **36**, Д.Пунцаг **36**, Л.Атарцэцэг **32**, Ч.Тунгалаг **31** удаа шүүх хуралдаанд тус тус оролцсон байна.

Танхимын тэргүүн нийт **676** захирамж гаргаснаас шүүх бүрэлдэхүүнийг томилох тухай **636**, харьяалал тогтоох тухай **27**, захиргааны хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тухай **7**, шүүх хуралдааныг хойшлуулах тухай **4**, гомдол гаргаагүйд тооцох тухай **2** байна.

Тус танхим **5** удаа зөвлөгөөн хийж, Улсын Дээд шүүхийн 2008 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хуулийн тайлбарын төсөл болон бусад асуудлыг хэлэлцсэн байна.

### **Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа**

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн асуудлын цөм нь хуулийг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх талаар хуулийн албан ёсны тайлбар гаргах явдал билээ.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийт **16** тогтоол гаргаж, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдэд нийтлүүлэх, өөрийн вэб сайтад байршуулах зэргээр олон нийтийн хүртээл болголоо. Үүнд:

1. Монгол Улсын Олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Д.Батсайхан, О.Зандраа/
2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан/
3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч П.Цэцгээ/
4. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан/
5. Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг булаах” гэмт хэргийг 147 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Ч.Ганбат/
6. Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах, санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийг хүнийг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх талаар /Шүүгч Б.Доржготов/
7. Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Пунцаг/
8. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/
9. Монгол Улсын Сонгуулийн Төв байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/
10. Орон сууцны болон орон сууц хувьчлах тухай хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч А.Доржготов/
11. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/
12. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Б.Бат-Эрдэнэ/
13. Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч С.Нямжав/
14. Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Б.Ундрах, П.Цэцгээ/



15. Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Тунгалаг/
16. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Бямбаа/

Нийт шүүгчдийн хуралдаанаар сүүлийн 3 жилд салбар эрх зүйн хууль тогтоомжийг цогцоор нь тайлбарлах, хуулийн хэрэглээ болон албан ёсны тайлбарын хоорондын уялдаа холбоог сайжруулах талд түлхүү анхаарал хандуулан ажиллаж ирлээ. Тухайлбал,

#### **Эрүүгийн эрх зүйн чиглэлээр:**

1. “Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйл /Эд хөрөнгө хураах/-ийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай” /Шүүгч С.Нямжав/ 2006 он
2. “Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан/ 2006 он
3. “Эрүүгийн хуулийн 60 дугаар зүйлийг тайлбарлах тухай” /Шүүгч Б.Доржготов/ 2006 он
4. “Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан/ 2006 он
5. “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Ч.Ганбат/ 2006 он
6. “Өршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хэрэглэх тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Ч.Ганбат/ 2006 он
7. “Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг Иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим ойлголтыг тайлбарлах тухай” /Шүүгч С.Нямжав/ 2006 он
8. Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Доржготов/ 2007 он
9. Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар /Шүүгч Б.Доржготов/ 2007 он
10. Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлийг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан/ 2007 он
11. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай /Шүүгч Ч.Ганбат/ 2007 он
12. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан/ 2008 он
13. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Д.Батсайхан/ 2008 он
14. Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг булаах” гэмт хэргийг 147 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар /Танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Ч.Ганбат/ 2008 он
15. Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах, санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийг хүнийг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх талаар /Шүүгч Б.Доржготов/ 2008 он
16. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Б.Бат-Эрдэнэ/ 2008 он
17. Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч С.Нямжав/ 2008 он

#### **Иргэний эрх зүйн чиглэлээр:**

1. “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаг/ 2006 он
2. “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн О.Зандраа/ 2006 он
3. Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч А.Доржготов/ 2007 он
4. Компанийн тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч А.Доржготов/ 2007 он

5. Орон сууцны болон орон сууц хувьчлах тухай хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч А.Доржготов/ 2008 он
6. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2008 он
7. Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Б.Ундрах, П.Цэцгээ/ 2008 он
8. Гэр бүлийн болон Иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Тунгалаг/ 2008 он

#### **Процессийн эрх зүйн чиглэлээр:**

1. “Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн О.Зандраа/ 2006 он
2. “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 326 дугаар зүйлийн 326.1, 353 дугаар зүйлийн 353.4 дэх хэсгийг тайлбарлах тухай” /Шүүгч Б.Бат-Эрдэнэ/ 2006 он
3. “Шүүхийн шийдвэрийн тухай” /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Д.Батсайхан, О.Зандраа/ 2006 он
4. “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн О.Зандраа/ 2006 он
5. “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Пунцаг/ 2006 он
6. “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан, Ц.Амарсайхан/ 2006 он
7. Иргэний зарим хэргийн харьяаллыг захиргааны хэргийн харьяаллаас зааглан ялгах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан, О.Зандраа/ 2007 он
8. 2007 оны 8 дугаар сарын 9-ний Улсын Их Хурлаар батлагдсан Эрүүгийн Байцаан Шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэх журмын тухай /Шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Доржготов/ 2007 он
9. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт дагаж мөрдөх журмын тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2007 он
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Б.Ундрах/ 2007 он

#### **Татварын эрх зүйн чиглэлээр:**

1. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.18, 9.2.19 дахь заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов/ 2006 он
2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Атарцэцэг/ 2007 он
3. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Пунцаг/ 2007 он
4. Онцгой албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Ч.Тунгалаг/ 2007 он
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч П.Цэцгээ/ 2007 он

#### **Нийгмийн халамж, хамгаалал-даатгалын эрх зүйн чиглэлээр:**

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тайлбарлах тухай /Шүүгч Ч.Тунгалаг/ 2007 он
2. Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Ч.Тунгалаг/ 2007 он
3. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай. /Шүүгч П.Цэцгээ/ 2007 он
4. Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Бямбаа/ 2007 он
5. “Хүүхдэд мөнгөн тусламж олгох, гэр бүлд тэтгэмж үзүүлэх тухай” хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Бямбаа/ 2006 он

6. Нийгмийн даатгалын тухай багц хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Бямбаа/ 2008 он

**Банк, санхүүгийн эрх зүйн чиглэлээр:**

1. “Банкны болон банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов, Л.Бямбаа/ 2006 он
2. “Иргэний хуулийн 44, 45, 46 дугаар бүлэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов, Л.Бямбаа/ 2006 он


**Төрийн эрх зүйн чиглэлээр:**

1. “Улс төрийн намын тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаа/ 2006 он
2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2008 он
3. Монгол Улсын Сонгуулийн Төв байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан / 2008 он

**Бусад:**

1. “Улсын Дээд шүүхийн 2003 оны 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” /Танхимын тэргүүн Д.Батсайхан/ 2006 он
2. “Автотээврийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2006 он
3. “Эмийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов/ 2006 он
4. “Улсын хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаа/ 2006 он
5. “Эрчим хүчний тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч А.Доржготов/ 2006 он
6. “Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч Д.Тунгалаа, Б.Ундрах/ 2006 он
7. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” /Шүүгч П.Цэцгээ/ 2006 он
8. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2007 он
9. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч П.Цэцгээ/ 2007 он
10. Боловсролын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай 2007 он
11. Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2007 он
12. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Пунцаг/ 2007 он
13. Монгол Улсын Олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай /Танхимын тэргүүн Ц.Амарсайхан/ 2008 он
14. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч П.Цэцгээ/ 2008 он
15. Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Пунцаг/ 2008 он

## Хуулийн тайлбар, түүний ангилал



Сүүлийн 3 жилд бид хууль тайлбарласан 66 тогтоол гаргажээ.

Дээрх хуулийн тайлбарууд нь тодорхой төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний асуудлаар гарч байсан хүндрэл бэрхшээлийг арилгах, зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах иргэдийн баталгаа нэмэгдэх, нийгмийн олон талт харилцааг хуулийн хүрээнд зохицуулах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмэр оруулж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд шүүхийн үйл ажиллагаанд нэгдсэн стандарт тогтоох, иргэд, хуулийн этгээдэд хүнд сурталгүй, чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үйлчилгээг үзүүлэх, ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, шүүхийн захиргааны удирдлага, түүний менежментийг шинэ түвшинд гаргах, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, зөв хувиарлах, зохион байгуулах чиглэлд илүү анхаарч ажиллалаа. Тухайлбал энэ оны байдлаар:

1. “Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчийн энгэрийн тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх, эзэмшүүлэх тухай” 2008 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн №09 тоот Ерөнхий шүүгчийн захирамж;
2. “Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам” /Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан захирамж, тушаал 2008,01,30 №07,26/;
3. “Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох заавар” /Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Цагдаагийн Ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын хамтарсан захирамж, тушаал 2008,11,10 №547, 494, А/113/ зэргийг тус тус батлан гаргажээ.

Мөн хугацаанд эрүүгийн хэргийн танхим зөвлөмж 4, тойм 4, иргэний хэргийн танхим зөвлөмж 7, тойм 4, захиргааны хэргийн танхим зөвлөмж 3, тойм 4-ийг нийт зөвлөмж 14, тойм 12-ыг гарган шүүхүүдэд хүргүүлснээс гадна “Дээд шүүхийн Мэдээлэл” сэтгүүлд хэвлүүллээ.

Улсын Дээд Шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүгчид **Завхан, Дархан-Уул, Баян-Өлгий, Баянхонгор, Ховд** аймгийн шүүхүүдийн ажлыг шалган туслаж, мэргэжлийн удирдлагаар ханган, холбогдох сургалтыг зохион байгууллаа.

Нийт шүүгчдийн хуралдаанаар дээрхи аймгуудын шүүхийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэж тогтоол гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүллээ.

### Гурав. Тамгын газрын ажлын талаар

Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээртэй уялдуулан гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар Тамгын газар санаачлагатай ажилласныг сайшаан тэмдэглэж байна.

Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2007 оны байдлаар гаргуулан авч, 17

шүүгчийн материалыг “Авлигатай тэмцэх газар”-т хүргүүлж, захиргааны албан хаагч **41** хүний материалыг тамгын газарт зохих журмын дагуу хадгалж байна.

Шүүгч, ажилтнуудын нөхөн тоо бүртгэлийг зохих журмын дагуу тайлагнаж, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүллээ.

Тамгын газрын даргын зөвлөл **4** удаа хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **20** гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **103** тушаал гаргасан байна.

Одоо тамгын газрын харъяа албадын ажлын талаар товч дурдья.

## **1. Ерөнхий шүүгчийн ажлын алба**

Тус алба нь тайлангийн хугацаанд **33** албан бичиг, **179** өргөдөл, гомдол, хүлээн авч цаг тухайд нь хариуг нь өгсөн бөгөөд одоо **5** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **93**, иргэний **158**, захиргааны **49**, нийт **300** хэрэг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулснаар Ерөнхий шүүгч эрүүгийн **7**, иргэний **3**, захиргааны **1** хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр дүгнэлт бичиж, **275** хэрэгт хариу өгчээ. Одоо эрүүгийн **4**, иргэний **6**, захиргааны **4** хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Ерөнхий шүүгч, түүний ажлын албаны дарга нар бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгч **178** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гаригт хүлээн авч уулзаж, тэдний санал, хүсэлтийг сонсож, шийдвэрлэжээ.

Мөн хугацаанд тухайн алба нь **243** албан бичигт холбогдох хариуг өгчээ.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс анхан болон давж заалдах, дагнасан шүүхийн ерөнхий шүүгч, Тамгын хэлтсийн дарга нарт өгсөн үүрэг, биелэлтийн явц байдлын талаар Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга М.Дамирансүрэн, шүүн таслах ажиллагаа хариуцсан референт З.Нацаг нар **Дархан, Сэлэнгэ, Хэнтий, Сүхбаатар, Булган, Орхон, Ховд, Увс, Архангай, Өвөрхангай** аймгийн шүүхийн хамт олонд мэдээлэл хийж, дээрхи үүргийг тухайн шүүхийн удирдлага хэрхэн зохион байгуулж байгаатай танилцан, цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан байна.

## **2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба**

2007 оны бүтэн жил, 2008 оны эхний хагас жил болон 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны дүнгийн тухай, түүнчлэн шүүгчийн ёс зүйн байдлын талаар хэвлэлийн бага хурлууд зохион байгуулж **7** телевиз, өдөр тутмын хэвлэлүүдээр мэдээллээ.

Өдөр тутмын сонины тоймыг Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнүүдэд тогтмол бэлтгэн өгч ажиллажээ.

“Өдрийн сонин”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ”, “Монголын сэтгүүлчдийн нэгдсэн холбоо”-ны удирдлагуудтай уулзан шүүхийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг олон нийтэд хүргэх хамтын ажиллагааны эхлэлийг тавьлаа.

Шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой гарсан мэдээллийг **7** хоногоор бэлтгэн Ерөнхий шүүгчид танилцуулж, мэдээллийн мөрөөр “Шүүгчдийн холбоо”-ноос **4** мэдэгдэл, бусад холбогдох мэдээ, мэдээлэл, тайлбарыг MN, TV5, TV25, Eagle болон бусад телевиз, Монголын радиогийн “Хурд” агентлагийн болон хууль эрх зүйн “Соёмбо” хөтөлбөрөөр тус тус нэвтрүүллээ.

Ерөнхий шүүгч болон танхимын тэргүүнүүд, орон нутгийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын ярилцлагыг “Өдрийн сонин”, “Зууны шуудан” сонинд нийтлүүлжээ.

УИХ-ын болон Орон нутгийн сонгуультай холбоотойгоор Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний ярилцлага болон Нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлсэн хариуг бүрэн эхээр нь “Өдрийн сонин”-д нийтлүүлж, “Монгол телевиз”-ийн “Тоймчийн хөтөлбөр” нэвтрүүлгээр мэдээллэх ажлыг зохион байгууллаа.

2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр үүссэн нийтийн эмх замбараагүй байдалтай холбогдуулан гаргасан Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Онц байдал тогтоох тухай” зарлигын дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн “Онц байдал тогтоосонтой холбоотой авах арга

хэмжээний тухай” захирамжийг Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизээр нийтэд нэвтрүүлсэн байна.

Мөн шүүхийн үйл ажиллагааг сурталчлах, шүүхийн хараат бус байдал болон эрүүгийн зарим хэргийн шийдвэрлэлтийн талаар **4** нийтлэл бичиж, хэвлүүлэв.

Монголын радиогийн “Хурд” агентлагийн болон хууль эрх зүйн “Соёмбо” нэвтрүүлгээр шүүн таслах болон бусад үйл ажиллагаатай холбоотой **15** мэдээг бэлтгэн өгч нэвтрүүлжээ.

Нийслэл, Нийслэлийн захиргааны хэргийн шүүх, аймгуудын шүүхээс ирүүлсэн мэдээг боловсруулж өдөр тутмын сонин, MN, TV5, UBS телевизийн мэдээгээр олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Шүүхийн үйл ажиллагааны тухай мэдээллийг давхардсан тоогоор **158** удаа хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулсан байна.

### **3. Шүүхийн судалгааны төв**

Судалгааны төв нь шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэж буй талаар дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга замыг тодорхойлох, хуулийн тайлбар гаргахад судалгаа хийх, төсөл боловсруулах зэрэгт түлхүү анхааран ажиллажээ.

“Дээд шүүхийн мэдээлэл”, “Монголын төр, эрх зүй”, сэтгүүлийг эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгож байна. Мөн “Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх онол практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэл, Улсын Дээд шүүхийн зөвлөмж, хууль тайлбарласан тогтоол зэргийг эмхтгэн хэвлүүлж, “Монгол Улсын шүүхийн 2007 оны жилийн тайлан”-г гаргажээ.

Түүнчлэн нийт шүүхийн хэмжээнд дагаж мөрдөх заавар, дүрэм, журам боловсруулахад судалгаа хийх, санал өгөх зэргээр оролцсон байна. Жишээ нь: “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны албан ёсны статистик мэдээ, мэдээллийн тайланг хүргүүлэх заавар”, “Сэтгүүл эрхлэн гаргах, түүнийг түгээх журам”-ын төслийг боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулжээ.

Шүүн таслах ажиллагааны статистик, тоон мэдээллийг 2008 оны эхний хагас болон бүтэн жил, I, II, III, IV улирлын мэдээг нэгтгэн гаргаж, хянах ажлыг зохион байгуулав.

Эрх зүйн системчлэл, мэдээлэлийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хяналт тавих ажлыг гүйцэтгэв. Жишээ нь: Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2005-2008 онд гаргасан хүчинтэй байгаа **38** захирамжийг нэгдсэн санд оруулжээ.

Шинээр хууль **93**, нэмэлт, өөрчлөлт орсон хууль **59**, хүчингүй болсон хууль **64**;

Улсын Их Хурлын шинээр баталсан **78**, өөрчлөлт оруулсан **5**, хүчингүй болсон **15** тогтоол;

Засгийн газрын шинээр баталсан тогтоол **180**, өөрчлөлт оруулсан **18**, хүчингүй болсон **34** тогтоол;

Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол **13**, Ерөнхий шүүгчийн хамтарсан захирамж, тушаал **5**-ыг шүүхийн мэдээллийн санд оруулжээ.

Засгийн газрын 1998 оны **65**, 1999 оны **229**, 2000 оны **204**, 2001 оны **289**, 2002 оны **272**, 2003 оны **278**, 2004 оны **250**, 2005 оны **267**, 2006 оны **316** тогтоолыг шүүхийн мэдээллийн санд оруулав.

Мөн эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай хоёр талын олон улсын гэрээ **12**-ыг шүүхийн мэдээллийн санд оруулжээ.

Шүүхийн ажилтнууд болон хуульчдад давхардсан тоогоор нийт **180** хүнд лавлагаа өгсөн байна.

Үндсэн Хуулийн Цэц, Гадаад Харилцааны яам, Байгаль орчны яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл судалгааны төв, Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, “Эмнести интернэшнл”, Германы техник, хамтын ажиллагааны нийгэмлэг зэрэг байгууллагуудтай судалгаа, эрдэм шинжилгээний чиглэлээр хамтарч ажиллажээ.

### **4. Санхүү, хангамж, үйлчилгээний алба**

Улсын Дээд шүүх 2008 онд урсгал зардалд **767,9** сая төгрөг, улсын төсвөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтад **189,9** сая төгрөг, нийт **957,8** сая төгрөгийн төсөв батлуулсан билээ.

Дээрх батлагдсан төсвийг зардлын ангилал, зохих журмын дагуу зарцуулж, хяналт тавьж, санхүүгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь гаргаж өгч ирсэн байна.

Тайлангийн хугацаанд 2007 оны төсвөөс хэмнэгдсэн **4,3** сая төгрөг, 2008 оны гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлаас хэмнэгдсэн **15,9** сая төгрөг, нийт **20,2** сая төгрөгөөс:

- урсгал засвар болон эд хогшил худалдан авах, дотоод томилолт, хичээл үйлдвэрлэлийн задлага хийх зардалд шилжүүлэн байгууллагынхаа бүх авто машинуудад дугуй худалдан авахад **4,8** сая төгрөг;
- шүүх хуралдааны танхимуудад ус цэвэршүүлэгч аппарат, танхим тус бүрт ноорог устгагч, хувилагч машин, мөн зөөврийн компьютер, видео камер, шарлагын УВЧ аппарат зэргийг худалдан авахад **13,9** сая төгрөг;
- дотоод томилолтын зардалд **407,5** мянган төгрөг;
- Захиргааны хэргийн танхимаас Нийслэлд зохион байгуулсан сургалтад орон нутгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчдийн туслахуудын ирэх, буцах унааны зардалд **992,7** мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

2008 оны **хөрөнгө оруулалтын** зардалд батлагдсан **189,9** сая төгрөгийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу нээлттэй тендер зарлан, сонгон шалгаруулж:


- Улсын Дээд Шүүхийн шинээр баригдах барилгын талбайн төмөр хашаа худалдан авах, тээвэрлэх, барихад **7,3** сая төгрөг;
- Байгууллагын гадна болон давхар тус бүрт хяналтын камер худалдан авч, суурилуулахад **6,3** сая төгрөг;
- Шүүгч, ажилтнуудад иж бүрэн компьютер **60**, тог баригч **60**, хэвлэгч **10**, LCD дэлгэц **2**-г худалдан авахад **56,7** сая төгрөг;
- Тамгын газрын захиргааны болон үйлчилгээний **2** албан хаагчид Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, “**Туулын хөвөө**” хотхоноос хоёр өрөө, **2** орон сууц худалдан авахад **119,6** сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

2008 оны ээлжийн амралтаар өөрийн буюу эхнэр, нөхрийн төрсөн нутагт очиж амарсан шүүгч, ажилтан **11** хүнд унааны зардалд **670,6** мянган төгрөгийг тооцон олгосон байна.

Ерөнхий шүүгчийн гадаад томилолт болон гадаад зочны зардлуудаас хэмнэгдсэн **23,1** сая төгрөгийг шүүгч, ажилтан нийт **10** хүнийг **Малайз** улсад сургалтад хамруулахад зарцууллаа.

Шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүн **60** хүнд нийт **10,9** сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосноос, захиргааны албан хаагч **3**, үйлчилгээний албан хаагч **10**, нийт **13** хүнд тус бүрт нь **500,0** мянган төгрөгийн буцалтгүй тусламжийг олгожээ.

**Сүүлийн 3 жилд шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүдэд буцалтгүй тусламжинд олгосон мөнгөн дүн**




Тайлангийн хугацаанд шүүгч, ажилтнуудын дундаж цалин **101,800** төгрөгөөр, хоолны мөнгийг шинэчлэн тогтоож **1500** төгрөгөөс **3500** төгрөг, захиргааны болон үйлчилгээний


албан хаагчдын унааны зардлыг мөн шинэчлэн тогтоож **200** төгрөгөөс **600** төгрөг болгон нэмэгдүүллээ.

Цалин, хоолны мөнгө, унааны зардлын өсөлтийг сүүлийн **3** жилийн байдлаар харуулбал,

Цалингийн өсөлт



Хоол, унааны мөнгөний өсөлт



2008 онд үр бүтээл, санаачлага, идэвх, зүтгэл гарган ажилласан тус шүүхийн шүүгч, ажилтнууд болон бусад байгууллагын ажилтан нийт **58** хүнийг **22,385,564** төгрөгөөр шагнаж урамшуулжээ.

Төрийн өмчийн хорооны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай” 2008 оны 167, “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын ажлыг зохион байгуулах тухай” 2008 оны 282 дугаар тогтоолуудын дагуу эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр **2** удаа явуулж:


- **162,3 сая** төгрөгийн конторын барилга;
- **119,6 сая** төгрөгийн **2** орон сууц;
- **301,6 сая** төгрөгийн **7** автомашин;
- **361,6 сая** төгрөгийн тавилга, эд хогшил;
- **0,6 сая** төгрөгийн санхүүгийн программ хангамж;
- **6.2 сая** төгрөгийн номын фонд, нийт **979,4 сая** төгрөгийн эд хөрөнгө тоологджээ.

Тооллогын явцад хуучирч муудсан ашиглалтын шаардлага хангахгүй болсон **64** нэр төрлийн **18,9 сая** төгрөгийн эд хогшлыг актлах, илүүдэлтэй байгаа **84,7 сая** төгрөгийн эд хөрөнгийг шилжүүлэх тухай саналыг Төрийн өмчийн хороонд тус тус гарган шийдвэрлүүлж **Нийслэлийн шүүх, Нийслэлийн захиргааны хэргийн шүүх, Баянхонгор, Дорнод, Төв, Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Орхон, Сүхбаатар, Дундговь, Сэлэнгэ** аймгийн шүүхүүдэд балансаас балансад шилжүүллээ.


Улсын Дээд шүүхийн **урсгал зардал** сүүлийн **3** жилд **326,3 сая** төгрөгөөс **767,8 сая** төгрөг болж **2,3** дахин, **хөрөнгө оруулалт** **90,8 сая** төгрөгөөс **189,9 сая** төгрөг болж **2** дахин нэмэгдэж батлагдсан байна.



## Урсгал зардлын төсөв



## Хөрөнгө оруулалтын төсөв



Жил бүрийн төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулан батлуулсны үр дүнд тус шүүхийн автомашины парк бүрэн шинэчлэгдэж, шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник, тоног төхөөрөмжөөр хангагдаж, конторын барилгад их засвар хийснээр тохилог орчинд, тав тухай ажиллах орчин нөхцлийг бүрдүүлжээ.

Ирэх жил шүүгч, ажилтнуудад үйлчилж буй “Delica” маркын микроавтобусыг шинэчилнэ.

### 5. Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын алба

Тайлангийн хугацаанд тус алба нь нийт **716** өргөдөл гомдол, **445** албан бичиг, **2132** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3630** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Мөн хугацаанд **Ж.Наранпүрэвийг** Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны даргын, **Д.Оюунбилэгийг** Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны даргын, **Х.Цэнгэлийг** Ерөнхий шүүгчийн туслах-ахлах шинжээчийн, **Б.Айбекийг** Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээчийн, **Б.Хишигсүрэнг** Төсвийн асуудал хариуцсан шинжээч-нягтлан бодогчийн, **Ч.Цэндийг** Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээчийн, **Б.Мөнхзул, Э.Халиунбаяр, Н.Дамдинсүрэн** нарыг Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, **Г.Солонго, Б.Ундраа** нарыг Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээчийн, **Н.Мөнгөнцэцэгийг** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээчийн, **Ш.Даваадуламыг** захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээчийн, **Л.Одончимэгийг** Цагаатгалын ажил хариуцсан шинжээчийн, Г.Гандмааг Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийн, **Ч.Жаргалсайханг** хууль тогтоомжийн системчлэлийн ажил хариуцсан ахлах зааварлагчийн, **Р.Ганпүрэвийг** Хэвлэл мэдээлэлийн төлөөлөгч-ахлах зааварлагчийн, **Т.Майцэцэгийг** Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан зааварлагчийн, **М.Баясгаланг** Дотоод ажил, зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний, **А.Ариунболорыг** эмчийн, **С.Баянмөнхийг** жолоочийн, **Б.Ганхуягийг** Сантехникийн слесарь-манаачийн ажил, албан тушаалд бүр болон түр хугацаагаар Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж байна.

Сүүлийн 3 жилд тамгын газрын ажилтнуудын ачаалалыг тэнцвэржүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээч-1, Төсвийн асуудал хариуцсан шинжээч-нягтлан бодогч-1, эмч-1, сантехникийн слесарь-1 нийт 4 орон тоог шинээр нэмж, одоо Тамгын газар нийт 60 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ онд Ерөнхий шүүгчийн туслах-ахлах шинжээч **И.Ганбат** Чингэлтэй дүүргийн шүүхийн, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Л.Ганзориг** Баянзүрх дүүргийн шүүхийн, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээч **Г.Есөн-Эрдэнэ** Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах- шинжээч **М.Пүрэвсүрэн** Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Б.Цолмонбаатар** Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн, Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээч **Ч.Отгонбаяр** Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус дэвшин томилогдлоо.

Сүүлийн 3 жилийн байдлаар Улсын Дээд шүүхийн тамгын газрын захиргааны ажилтнуудаас 15 хүн шүүгчийн албан тушаалд томилогдсноос 5 нь орон нутагт ажиллаж байна.



Судалгааны төвийн захирал **Ч.Нямсүрэн**, мөн төвийн Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээч **Б.Айбек**, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах референт **Н.Долгорсүрэн**, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах-шинжээч **Ө.Уянга**, Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч **Д.Хулан**, үйлчлэгч **Д.Оюунчимэг** нарт төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн болон эрдмийн зэрэг цолны нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр”, Олон Улсын Эмэгтэйчүүдийн баярын өдөр “Мартын 8”, “Хүүхдийн баяр”, “Ахмадын баярын өдөр” зэрэг тэмдэглэлт баяруудыг тохиолдуулсан арга хэмжээг тухай бүр зохион байгуулж, ойн баяр болон тэмдэглэлт өдрүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч “Онц байдал зарлах тухай” зарлиг гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор 4 удаагийн тушаалаар 25 ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Сахилгын зөрчил гаргасан 1 ажилтанг Тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж, ажлаас халсан байна.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2008-2009 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт 3 оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлжээ.

Шүүгч, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Улаанбаатар банк”-ны удирдлагуудтай харилцан тохиролцож, 10 жилийн хугацаатай, 50 сая хүртэлх төгрөгийн, 0,6 хувийн хүүтэй орон сууцны зээлд нийт 11 хүн хамрагдлаа. Цаашид уг зээлд шүүгч, ажилтнуудыг хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хуулийн төв байгууллагын спортын тэмцээн”-д Улсын Дээд шүүхийн баг тамирчид амжилттай оролцож, багийн нийлбэр дүн 40,5 оноогоор 2 дугаар байрт шалгарлаа.

## Дөрөв. Гадаад арга хэмжээний талаар

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжиж, шүүгч, ажилтнууд гадаад сургалтад хамрагдах явдал нэмэгдэж байна.

Тайлангийн хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан орон нутгийн давж заалдах шатны шүүхийн 9 шүүгчийн бүрэлдэхүүнтэй 2008 оны 4 дүгээр сарын 17-ноос 5 дугаар сарын 1-ний хооронд **Тайваны** шүүгчдийн давтан сургалтын төвд 14 хоногийн сургалтад хамрагдлаа.

Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа тэргүүтэй зарим анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, тамгын хэлтсийн дарга 25 хүн 2008 оны 5 дугаар сарын 17 - 31-ний өдрүүдэд **БНХАУ**-ын Ардын Дээд шүүхийн Шүүгчдийн сургалтын төв болон **Тянжин** хот дахь сургалтын төвийн салбарт зохион байгуулагдсан **“БНХАУ-ын шүүхийн тогтолцоо, шүүгчийн ёс зүй, хэргийн хөдөлгөөний менежмент”** сэдэвт 14 хоногийн сургалтад оролцжээ.

Мөн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан **ОХУ**-ын **Владивосток** хотноо 2008 оны 9 дүгээр сарын 25 - 27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан **“Ази, Номхон далайн орнуудын хамтын ажиллагааны чуулга уулзалт”**-нд оролцлоо.

Улсын Дээд шүүхийн шүүгч, Ч.Ганбат, А.Доржготов, Д.Пунцаг, тамгын газрын ажилтан С.Баасанцэрэн, Н.Долгорсүрэн, Ш.Даваадулам, Д.Хулан, Д.Алтанцэцэг, Ч.Отгонбаяр, Б.Батболор нарын 10 хүн 2008 оны 11 дүгээр сарын 19 - 25-ны хооронд **Малайз** улсад англи хэлний сургалтад хамрагдлаа.

Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, Л.Атарцэцэг нарын 10 шүүгч Ханнс-Зайделийн сангийн шугамаар **ХБНГУ**-ын Бавари мужийн Мюнхен хотод 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 7-ны хооронд зохион байгуулагдсан Захиргааны хэргийн шүүхийн шүүгч-багш нарын сургалтад оролцлоо.

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн **“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах”** төслийн шугамаар Монгол Улсын шүүхийн мониторингийг хэрэгжүүлэх зөвлөлийн дарга, Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, ажлын хэсгийн ахлагч шүүгч Б.Бат-Эрдэнэ, Л.Бямбаа, Ч.Тунгалаг, зөвлөлийн гишүүн Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун нар **ХБНГУ**-ын **Хессен** мужийн шүүхэд ажлын айлчлал хийж, туршлага судаллаа.

Шүүгч Б.Доржготов, Налайх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Л.Гансүх, Ховд аймгийн шүүхийн шүүгч Д.Алимаа, Улсын Дээд шүүхийн гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах референт Н.Долгорсүрэн нар **БНЭУ**-д 12 дугаар сарын 10 - 18-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 9 дүгээр бага хуралд оролцлоо.

Улсын Дээд шүүхийн Судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн **ОХУ-н Эрхүү** хотноо 2008 оны 12 дугаар сарын 5 өдөр зохион байгуулагдсан **“Дорнод Сибирийн бүс дэх дотоод хэргийн байгууллагуудын шинжилгээ судалгааны ажлыг боловсронгуй болгох нь”** сэдэвт дугуй ширээний ярилцлагад, Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээч Б.Айбек 2008 оны 12 дугаар сарын 12 - 14-ний өдрүүдэд **ОХУ**-ын **Улан-Удэ** хотод зохион байгуулагдсан **“Хар тамхитай тэмцэх зарим асуудал”** сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тус тус илтгэл хэлэлцүүлж оролцжээ.

“Жайка” байгууллагаас 2008 оны 2 дугаар сарын 25-наас 3 дугаар сарын 14-ний хооронд **Япон** улсад зохион байгуулагдсан **“Азийн орнуудын эрх зүйн хөгжил ба Үндсэн хуулийн эрх зүй”** сэдэвт сургалтад Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Ц.Сайхантуяа хамрагдсан байна.

## Тав. Сургалт, семинарын талаар

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2008 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 32 дугаар захирамжаар **“Шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудын сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөө”**-г шүүхийн хэмжээнд анх удаа баталлаа.

Дээрх хөтөлбөр, төлөвлөгөө нь шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудын мэргэшил, мэдлэгийн түвшин, ажил хэргийн чадварыг эрх зүйн онолын чиг хандлага, нийгмийн хөгжлийн

шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, эрх зүйн онолын мэдлэгийг бататгах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой баримт бичиг болно гэж үзэж байна.

Хөтөлбөрт тусгагдсанаар шүүхийн сургалтын нэгдсэн тогтолцоо нь:

- Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагаа;
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа;
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа;
- Шүүгчийн тусгай сургалт;
- Шүүхийн захиргааны удирдлага;
- Хуульчийн үргэлжилсэн сургалтуудаас бүрдэнэ.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлийн сургалтыг ГТХАН-ийн туслалцаатайгаар бэлтгэгдсэн шүүгч-багш нар 2007 оноос эхлэн бие даан, өөрсдөө зохион байгуулж, удирдан явуулж байна.

Энэ онд “Ханнс-Зайделийн сан”-ийн тусламжтайгаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлийн шүүгч-багш нарыг бэлтгэсэн бөгөөд тэдгээр нь ирэх жилээс эхлэн холбогдох сургалтыг орон нутагт зохион байгуулна.

2009 онд Эрүүгийн шүүн таслах ажиллагааны чиглэлийн шүүгч-багш нарыг мөн “Ханнс-Зайделийн сан”-ийн тусламжтайгаар бэлтгэхээр төлөвлөж байна.

Эрүү, иргэний хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслахууд орон нутагт очиж, газар дээр нь сургалт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх талд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж ирлээ. Тухайлбал,

1. Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслахууд **Сүхбаатар, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган** аймгийн болон Нийслэлийн **Багануур** дүүргийн анхан, давж заалдах шатны шүүхийн шүүгч, ажилтнуудад анхаарал татаж буй зарим нэг ноцтой хэргүүдийг шүүхээс хэрхэн шийдвэрлэж байгаа байдал, оногдуулах ялын бодлого дээр цаашид анхаарах зарим асуудлын талаар;

2. Иргэний хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслахууд **Архангай, Өвөрхангай** аймгийн болон **7** дүүргийн шүүхийн шүүгч, ажилтнуудад **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд зориулж гаргасан тайлбар, зөвлөмжийн талаар”** тус тус сургалт - семинарыг зохион байгуулсан нь ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Цаашид эдгээр сургалтыг үргэлжлүүлэн явуулах болно.

2008 оны байдлаар Улсын Дээд шүүх дараахь сургалт, семинарыг зохион байгуулж, мөн оролцсон байна. Үүнд:

1. 2008 оны 1 дүгээр сарын 28 - 31-ны өдрүүдэд анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын хэлтэс, албаны дарга нарын 2008 оны **нэгдсэн зөвлөгөөнийг** “Хууль зүйн үндэсний төв”-д зохион байгууллаа.
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2008 оны 2 дугаар сарын 18-ны өдөр болсон **“Эрх зүйт төр-хууль ёсны хэрэгжилт”** сэдэвт Үндэсний зөвлөгөөнд Улсын Дээд Шүүхийн шүүгчид, Тамгын газрын дарга, Судалгааны төвийн захирал, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Аймаг, нийслэл, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчид оролцлоо.
3. Засгийн газрын захиалгын дагуу Удирдлагын академийн төрийн захиргааны **“гараг”**-ийн сургалтад Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах **Ө.Уянга**, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах **И.Амартөгс**, Төрийн захиргааны менежерийн **“зайн”** сургалтанд Мэдээлэл, лавлаганы ажил хариуцсан зааварлагч **Т.Майцэцэг** нар хамрагдан суралцаж байна.
4. Иргэний хэргийн танхим, Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй хамтран 2008 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 2008 оны 05 дугаар сарын 17-ны өдрүүдэд **“Бусдын эзэмшил, ашиглалтад хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүргийн зохицуулалт, хууль хэрэглэх аргачлал”** сэдвээр нийт шүүхийн хэмжээнд нэгдсэн сургалт зохион байгууллаа.
5. ГТХАН-ийн **“Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах”** төслөөс Монгол улсын шүүхийн мониторингийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2008 оны 09 дүгээр сарын 16 - 24-ний өдрүүдэд Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй хамтран Дээд шүүх, Нийслэлийн шүүх, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх, зарим аймаг, сум дунд, дүүргийн шүүхийн шүүгч, ажилтнуудад сургалт, семинар зохион байгууллаа.
6. Ажил олгогч эздийн холбоо болон дэлхийн хөдөлмөрийн байгууллагаас 2008 оны 11 дүгээр сарын 19 - 21-ны өдөр зохион байгуулагдсан **“Албадан хөдөлмөр болон хүний наймаа”** сэдэвт уулзалт, семинарт Улсын Дээд Шүүхийн эрүүгийн хэргийн шүүн

таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч Ц.Баярмаа, дотоод ажил, зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн М.Баясгалан нар оролцлоо.

7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан “Хүний эрх ба хүнд суртал” сэдэвт үндэсний чуулганд Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Доржготов, Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээч Б.Айбек, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга Б.Оюунбилэг нар оролцов.
8. Улсын дээд шүүхийн тамгын газрын хуульчийн гэрчилгээ бүхий 25 ажилтан 2008 оны 11 дүгээр сарын 12 - 14-ны өдрүүдэд “Хуульчийн үргэлжилсэн сургалт”-д хамрагдлаа.

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх, зүтгэл, үр бүтээл гарган ажилласан танхимын тэргүүн Д.Батсайхан, Ц.Амарсайхан, шүүгч Б.Ундрах, Б.Доржготов, Ц.Сумъяа, П.Цэцгээ, Д.Пунцаг, Ч.Ганбат, А.Доржготов, Албаны дарга С.Баасанцэрэн, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах референт Н.Долгорсүрэн, Ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, танхимын тэргүүний туслах Ч.Отгонбаяр, Ч.Цэнд, Ө.Уянга, шүүгчийн туслах И.Амартөгс, Д.Алтанцэцэг, Б.Батболор, Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч Д.Хулан, Захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч Ш.Даваадулам, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч Л.Одончимэг, Компьютерийн программ хангамж хариуцсан шинжээч С.Сундуйжав, Шүүхийн статистик тоон мэдээлэл хариуцсан ахлах зааварлагч Д.Оюунчимэг, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагч Г.Гандмаа, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр, Эмч А.Ариунболор, Жолооч Б.Энхжаргал, Э.Цог-Эрдэнэ, Үйлчлэгч Л.Даваажав, Ц.Цэцэгсүрэн, Д.Оюунцэцэг, Мужаан С.Мөнхбаяр нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

### **Эрхэм шүүгч, ажилтнууд аа!**

Улирч буй 2008 онд бид амжилт бүтээл арвинтай байлаа. Морилон ирж буй 2009 онд түүнээс ч их зүйлийг хийж, амжуулах шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл гарган ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.